



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

---

# АУДИТЫН ТАЙЛАН

---

## ХОВД АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг  
хүсвэл дараах хаягаар  
харилцана уу:**

Ховд аймгийн Дарга, Тэргүүлэх  
аудитор Л.Галбадрах  
Утас: 70433061  
Цахим хаяг:  
[galbadrakh.l@audit.gov.mn](mailto:galbadrakh.l@audit.gov.mn)

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн  
Утас: 70432545  
Цахим хаяг:  
[tsetsegsuren.a@audit.gov.mn](mailto:tsetsegsuren.a@audit.gov.mn)

Шинжээч: Ц.Аззаяа  
Утас: 70433061  
Цахим хаяг:  
[Azzaya\\_ts@audit.gov.mn](mailto:Azzaya_ts@audit.gov.mn)

2017 ОНЫ 2 САР  
ХОВД ХОТ

## 1. АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ .....	
2	Аудитын тайлан .....	2
2.1	Оршил .....	2
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	2
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	2
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	3
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	3
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	4
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	4
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	5
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	5
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал .....	6
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал .....	
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	6
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	6
2.12	Шилэн дансны мэдээлэл .....	7
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	7
3	Менежментийн захидал .....	70
3.1	<u>«Анхаарал хандуулах асуудал 1»</u> .....	
3.2	<u>«Анхаарал хандуулах асуудал 2»</u> .....	
3.3	<u>«Анхаарал хандуулах асуудал 3»</u> .....	
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	91
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	9
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	13
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	15

## 2. АУДИТЫН ТАЙЛАН

### 2.1 Оршил

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

### 21. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Ховд аймгийн Цагдаагийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Ховд аймгийн Цагдаагийн газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 2 сарын 10-наас 15- ны хооронд хийж, аудитын тайланг 2 сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 1 сарын 24 -ны өдрийн 51-8/237 тоот албан бичгээр 2017 оны 1 сарын 25- нд төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

### 1.1 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын

системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

## **1.2 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

*Тус байгууллага нь "Хуулийг дээдлэн, хүний эрхийг хамгаалах, амар тайван амьдралын баталгааг хангах" эрхэм зорилгын хүрээнд хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан байна.*

*Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, холбогдох хууль тогтоомж, Засгийн газар, Ховд аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан цагдаагийн байгууллагатай холбоотой ажлын чиглэл, Цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг удирдлага болгон ажилласан байна.*

Ховд аймгийн Цагдаагийн газар нь нь дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхлэх асуудал, үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгууллагын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

*Байгууллагын төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:*

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Цагдаагийн албаны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

## **1.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ**

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн Цагдаагийн Ерөнхий газраас гаргасан бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байна.

Аудитын явцад байгууллагын дотоод хяналтын орчинг судалж холбогдох горимыг хэрэгжүүлэв.

Тус байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах гэж үзлээ.

Тус байгууллаган нь санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн "Accolus" програм хангамж ашиглажээ.

#### **1.4 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Төсвийн шууд захирагчийн 2016 оны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 3 асуудал эрсдэл дунд, 5 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин үнэлсэн болно.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 3 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

#### **1.5 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд төсвийн орлого дийлэнх хувийг эзэлж байгаатай холбоотой юм.

2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 31597,5 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 31,5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь аудиторын эрсдлийг бага түвшинд байлгахтай холбоотой юм.

#### 1.6 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 5 чиглэлээр эрсдэлтэй асуудалд 3 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	2	60,4	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	2	60,4	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

#### 1.7 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

### 1.7.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал /байхгүй /

### 1.8 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ.

Авч үзэх анхаарал хандуйлхуйц чухал асуудал байхгүй болно.

### 1.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Төсвийн шууд захирагч өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 527,2 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/сая, төгрөгөөр/

Д/А	Үзүүлэлт	Тайлант оны		Хувь	Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
1	1. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,457.50	2,441.00	99.35	16.00
1.1	1.1 УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,457.00	2,441.00	99.35	16.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
2	2 ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,457.50	2,441.00	99.33	16.50
2.1	2.1 ТЭШ САНХҮҮЖИХ	2,397.70	2,378.00	99.18	19.70
2.2	2.2 Өөрийн орлого	59.80	63.00		(3.20)

Төсөвт батлагдсан төсвийн дагуу 2397,7 сая төгрөгийн улсын төсвийн санхүүжилт, өөрийн ороогоор 59,8 сая, бүгд 2457,5 сая төгрөгийн зарлагын эх үүсвэр батлагджээ. Тайлант онд улмын төсвийн санхүүжилтэнд 2378,0 сая, өөрийн орлогоор 63,0 сая төгрөг бүгд 2441,0 сая төгрөгийн орлого бүрдүүлж санхүүжилтийг 19,7 сая төгрөгөөр дутуу авсан бол өөрийн орлогыг 3,2 сая төгрөгөөр давуулжээ.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар 101,2 сая төгрөгийн нэмэлт орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

#### 1.10 Шилэн дансны мэдээлэл

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад хуульд заасан мэдээлэлийг тогтоосон хугацаанд оруулж хэвшсэн байна.

#### 1.11 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөн бөгөөд хэрэгжсэн байна.

#### 1.12 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид аймгийн Цагдаагийн газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Ховд аймгийн Цагдаагийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж "Зөрчилгүй" санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

## 2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Ховд аймгийн Цагдаагийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.



Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

3.1 Асуудал Бараа материал,

Тэргүүлэх ач холбогдол №01

**Илрүүлэлт**

Байгууллагын бараа материалын тайлангаас орлого зардал, үлдэглийг хянахад зарим нэр төрлийн актлах шаардлагатай, хөрөнгийн зардалд зарцуулагдсан бага хэмжээний үнэ бүхий бараа материал байна. Тухайлбал, 2 кг ааруул, 4,5 сая төгрөгийн өртөг бүхий лаазалсан нөөцөлсөн мах үлдэгдлээр оршин байна.

**Зөвлөмж**

- Байгууллагын өмч хамгаалах зөвлөл болон няравын тооллогыг жилийн эцэст журамд заасны дагуу нэг бүрчлэн хийж бараа материалын үлэгдлийг үнэн зөв тайлагнах

**Хариуцах ажилтан**

Дарга Д.Мөнхболд  
Ня-бо Д.Рагчаадорж

**Эрсдэл**

Төсвийн үрэлгэн зардал бий болох ,

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.1 Асуудал 2 Орлого

Тэргүүлэх ач холбогдол №02

**Илрүүлэлт**

Тус байгууллагын орон нутгийн орлогод төвлөрүүлэх орлогыг аудитын хугацаанд хянахад Замын цагдаагийн торгуулийн бэлэн бус торгуулийн машинаар уншуулсан нийт орлого 2016 оны жилийн эцсийн мэдээгээр 80, сая төгрөг байгаагаас тайланд онд 19,6 сая төгрөгийн орлогыг торгууль бичүүлсэн иргэд тус дансанд тушаасан байна. Эндээс үзэхэд тус орлогын биелэлт 24 хувьтай байна.

**Зөвлөмж**

Шинээр нэвтрүүлж буй бэлэн бус машины орлогыг нэмэгдүүлэх, тайлант хугацаанд төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх

**Хариуцах ажилтан**

Дарга Д.Мөнхболд  
Ня-бо Д.Рагчаадорж

**Төсвийн захирагчийн хариу**

**Эрсдэл**

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх,  
зарлагын гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

/Төгрөгөөр/

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>125,031,780</b>	<b>176,389,572</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	3,000
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	3,000
3121	Төгрөг	-	3,000
31213	Арилжааны банк дахь харилцах		3,000
33	АВЛАГА	4,197,588	1,179,085
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,197,588	1,137,085
335	Бусад авлага	-	42,000
3351	Байгууллагаас авах авлага		42,000
34	УРЬДЧИЛГАА	-	12,257,817
3471	Урьдчилгаа тооцоо	-	12,257,817
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа		12,257,817
35	БАРАА МАТЕРИАЛ	120,529,032	162,849,396
351	Түүхий эд материал	62,447,220	75,624,125
35110	Тусгай зориулалттай материал	62,447,220	75,329,585
35130	Эм боох материал	-	294,540
354	Хангамжийн материал	45,779,813	41,713,271
35410	Бичиг хэргийн материал	2,717,000	1,063,000
35420	Аж ахуйн материал	13,321,421	13,321,421
35430	Сэлбэг хэрэгсэл	15,000	1,507,600
35450	Барилгын засварын материал	2,925,600	3,653,360
35460	Хүнсний материал	369,475	4,651,631
35470	Бусад хангамжийн материал	9,077,712	17,516,259

35600	Мал амьтад	12,302,000	45,512,000
<b>36</b>	<b>НОӨЦИЙН БАРАА</b>	305,160	100,274
36600	Бусад нөөц	305,160	100,274
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,732,905,552</b>	<b>2,143,298,170</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,732,905,552	2,143,298,170
<b>392</b>	<b>Биег хөрөнгө</b>	1,732,886,802	2,143,298,170
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,810,871,189	2,147,597,702
39202	Хуримтлагдсан элэгдэл	(503,401,912)	(547,982,376)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	367,758,412	610,336,482
39204	Хуримтлагдсан элэгдэл	(209,289,355)	(343,543,562)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	241,066,798	288,647,678
39206	Хуримтлагдсан элэгдэл	(93,429,748)	(138,201,690)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	65,606,983	89,295,713
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,223,009)	(39,125,690)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	45,908,236	45,908,236
39212	Хуримтлагдсан элэгдэл	(905,033)	(1,341,600)
39214	Бусад үндсэн хөрөнгө	54,347,714	54,347,714
39215	Хуримтлагдсан элэгдэл	(17,423,473)	(22,640,437)
39301	Програм хангамж	1,497,500	1,497,500
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,478,750)	(1,497,500)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I-II</b>	<b>1,857,937,332</b>	<b>2,319,687,742</b>
<b>4</b>	<b>НИЙТ ОР ТӨЛБӨР</b>	<b>9,397,025</b>	<b>42,000</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ОР ТӨЛБӨР</b>	9,397,025	42,000
413	Өглөг	9,397,025	42,000
4136	Бусад өглөг	5,205,050	42,000
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,589,400	42,000
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ОМЧИЙН ДҮН</b>	<b>1,848,540,307</b>	<b>2,319,645,742</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,848,540,307	2,319,645,742

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,311,973,037	1,311,973,037
51101	Өмч: - төрийн	1,311,973,037	1,311,973,037
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	340,242,916	811,348,351
51210	Өмнөх үеийн үр дүн	340,242,916	340,242,916
51220	Тайлант үеийн үр дүн		471,105,435
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	196,324,354	196,324,354
6	<b>ОР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,857,937,332</b>	<b>2,319,687,742</b>

**а. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2533732054.71</b>	<b>3,127,305,436</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>72904489.00</b>	<b>139,476,774</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	72904489.00	139,476,774
120004	Төсөв байгууллагын оорийн орлого	72904489.00	139,476,774
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19688850.00	13,577,844
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46498139.00	50,085,688
1200045	Үнэт хөрөнгөгүй хүлээн авсан орлого	6717500.00	75,813,242
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>2460827565.71</b>	<b>2,987,828,662</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2252850680.00	2,397,724,300
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2252850680.00	2,397,724,300
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	108466476.71	101,228,000
131103	ЗГНХ,ЗДНХөрөн огуунтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62800000.00	72,960,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		18,208,000
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	34942700.00	10,060,000
1330	<b>Төсвийн захирагчдаас</b>	99510409.00	488,876,362
133003	Хөрөнгийн	99510409.00	488,876,362
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2489205096.57</b>	<b>2,688,642,938</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2489205096.57</b>	<b>2,688,642,938</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛНИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2445012477.57	2,668,212,514

2101	<b>Цалин хөдөлгөөн болон нэмэгдэл урамшил</b>	1930827514.00	2,070,840,869
210101	Үндсэн цалин	1603178929.00	1,292,950,102
210102	Нэмэгдэл	327648585.00	728,587,985
210105	Гэрээт ажлын хөдөлгөөн		49,302,782
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	43097975.00	46,453,541
210201	Тэтгэврийн даатгал	43097975.00	46,453,541
2103	<b>Байр ашигдалтай холбоотой тогтмол зардал</b>	77425148.00	82,337,812
210301	Гэрэл, цахилгаан	9563400.00	14,750,000
210302	Түлш, халаалт	52028000.00	51,192,000
210303	Цэвэр, бохир ус	15833748.00	16,395,812
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	186694156.00	178,788,538
210401	Бичиг хэрэг	12093606.00	12,073,918
210402	Тээвэр, шатахуун	150374090.00	153,259,468
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9713953.00	11,373,052
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14378540.00	2,082,100
2105	<b>Нормативт зардал</b>	19272540.00	32,059,594
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	358750.00	200,000
210502	Хоол, хүнс	17489790.00	31,587,594
210503	Нормын хувцас, зоолон эдлэл	1424000.00	272,000
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	24311694.00	63,932,988
210604	Урсгал засвар	24311694.00	63,932,988
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	48677460.00	15,547,200
210702	Дотоод албан томилолт	48677460.00	15,547,200
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5999875.00	2,150,237
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	999900.00	321,500
210803	Даатгалын үйлчилгээ		346,500
210804	Тээврийн хэрэгслийн гатвар	884975.00	709,751

210807	Газрын толбөр		304000,00	400,000
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх			372,486
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		108706115.57	176,101,735
210901	Бараа үйлчилгээний бусад зардал			23,560,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх			572,644
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол		108706115.57	151,969,091
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		44192619.00	20,430,424
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		40192619.00	20,430,424
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		40192619.00	20,430,424
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>		<b>44526958.14</b>	<b>438,662,498</b>
145	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>		0.00	32,442,937
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз			32,442,937
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>		-9325133.18	32,442,937
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>		<b>35201824.96</b>	<b>471,105,435</b>

**б. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,311,973,037.12	196,324,353.50	340,242,916.11		1,848,540,306.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,311,973,037.12	196,324,353.50	340,242,916.11	0.00	1,848,540,306.73
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз,					0.00
C07	Тайланг үеийн үр дүн					0.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,311,973,037.12	196,324,353.50	340,242,916.11	0.00	1,848,540,306.73
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,311,973,037.12	196,324,353.50	340,242,916.11	0.00	1,848,540,306.73
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,311,973,037.12	196,324,353.50	340,242,916.11	0.00	1,848,540,306.73
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, суурьш					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз,					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайланг үеийн үр дүн			471,105,435.01		471,105,435.01
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,311,973,037.12	196,324,353.50	811,348,351.12	0.00	2,319,645,741.74

с. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайланг оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,428,152,146</b>	<b>2,562,111,175</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>66,186,989</b>	<b>63,158,875</b>
120	Нийтлэг татварын бус орлого	66,186,989	63,158,875
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	66,186,989	63,158,875
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,688,850	13,577,844
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,498,139	49,581,031
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,361,965,157</b>	<b>2,498,952,300</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,252,850,680	2,397,724,300
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,252,850,680	2,397,724,300
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	109,114,477	101,228,000
131103	ЗПНХ,ЗДНХоронго,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,800,000	72,960,000
131104	Дууд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		18,208,000
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	34,942,700	10,060,000
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРДАЛ А ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,357,288,469</b>	<b>2,514,260,785</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,357,288,469</b>	<b>2,514,260,785</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,313,095,850</b>	<b>2,493,830,361</b>
2101	Цалин зөле болон нэмэгдэл урамшил	1,943,345,977	2,067,709,352
210101	Үндсэн цалин	1,560,595,343	1,685,576,946
210102	Нэмэгдэл	382,750,634	347,891,903
210105	Гэрээт ажлын хөле		34,240,503
2102	Ажил олгогчдоо нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,777,100	46,022,898
210201	Тэтгэврийн даатгал	34,777,100	46,022,898
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,464,748	79,268,812
210301	Гэрэл, цахилгаан	10,944,000	14,750,000
210302	Түшиг зардал	50,687,000	48,123,000
210303	Цэвэр, бохир ус	15,833,748	16,395,812
2104	Хангамж, бараа материалын зардал	171,913,560	175,155,482
210401	Бичиг хэрэг	11,616,475	9,667,750
210402	Тээвэр, шатахуун	149,786,765	151,232,680
210403	Шуудан, холбоо, интернэтийн толбөр	9,849,953	12,210,052
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	526,400	2,045,000
2105	Норматив зардал	16,684,869	31,705,020
210501	Өм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	113,750	200,000
210502	Хоол, хүнс	15,147,119	30,331,920
210503	Нормын хувцас, зоолон эдлэл	1,424,000	1,173,100
2106	Эд хөгшил, урсгал засварын зардал	20,185,140	70,529,028
210603	Хөдөлгөөр хамгааллын хэрэглэл		742,000

210604	Урсгал засвар	20,185,140	69,787,028
2107	Томилголт, зөний зардал	45,620,460	18,604,200
210702	Дотоод албан томилголт	45,620,460	18,604,200
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	304,000	2,659,726
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		913,226
210803	Даангальн үйлчилгээ		346,500
210804	Тээврийн хэрэгсэлийн татвар		1,000,000
210807	Газрын төлбөр	304,000	400,000
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,799,996	2,175,843
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,499,996	2,116,725
210902	Хи гээл үйлдвэрлэлийн даллага хийх	300,000	59,118
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	44,192,619	20,430,424
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,192,619	20,430,424
213303	Товчруулах шилжүүлэг	40,192,619	20,430,424
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>70,863,677</b>	<b>47,850,390</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>70,863,677</b>	<b>47,847,390</b>
22	<b>ХӨРӨНГ ИЙН ЗАРДАЛ</b>	<b>70,863,677</b>	<b>47,847,390</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	70,863,677	47,847,390
225106	Биет ба биет бус хоронго худалдан авсан зардал	70,863,677	47,847,390
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(70,863,677)</b>	<b>(47,847,390)</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>0</b>	<b>3,000</b>
10	Мөнгө, түүргэи адилтгах хорөнгийн эцсийн үлдэгдэл		3,000

d. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,457,516,300	2,441,192,151
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,457,516,300	2,441,192,151
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,457,516,300	2,441,192,151
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,079,469,000	2,067,709,352



210101	Үндсэн цалин	1,674,896,500	1,685,576,946
210102	Нэмэгдэл	358,620,500	347,891,903
210104	Урамшуулал	39,792,000	34,240,503
<b>2102</b>	<b>Ажилт олгогчөөс нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	47,204,200	46,022,898
210201	Тэтгэврийн даатгал	47,204,200	46,022,898
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	79,640,000	79,268,812
210301	Гэрэл, цахилгаан	14,750,000	14,750,000
210302	Түлш, халаалт	48,130,000	48,123,000
210303	Цэвэр, бохир ус	16,760,000	16,395,812
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	170,876,700	170,867,482
210401	Бичиг хэрэг	9,670,500	9,667,750
210402	Тээвэр, шатахуун	148,572,000	148,432,680
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,589,200	10,722,052
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,045,000	2,045,000
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	18,180,000	15,841,020
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200,000	200,000
210502	Хөөл, хүнс	16,480,000	14,467,920
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000	1,173,100
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	32,227,100	32,096,428
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	720,000	742,000
210604	Урсгал засвар	31,507,100	31,354,428
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	16,668,300	16,660,200
210702	Дотоод албан томилголт	16,668,300	16,660,200
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,186,000	2,662,726
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000	916,226
210803	Даатгалын үйлчилгээ	500,000	346,500

210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,000,000	1,000,000
210807	Газрын толбор	400,000	400,000
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	10,065,000	10,063,233
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,017,000	10,004,115
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	48,000	59,118
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,457,516,300	2,441,195,151
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,397,724,300	2,378,033,276
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,397,724,300	2,378,033,276
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	20,000,000	49,584,037
132001	Орон нутгийн төсвөөс	20,000,000	49,584,037
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	39,792,000	13,577,838
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,450,000	5,830,688
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,342,000	7,747,150

АУДИТЫН ТАЙЛАН ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ГАЛБАДРАХ

Огноо: 2017. 02.15

БЭЛТГЭСЭН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

Огноо: 2017. 02.15

